



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1/222

Ховд

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь заалт, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.6 дахь заалт Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 165 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын "Бүсчилсэн хөгжлийн бодлого"-д тусгах аймаг орон нутгийн саналыг боловсруулах хэлэлцүүлэг зохион байгуулах, нэгдсэн тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн Үндэсний хөгжлийн газарт уламжлах үүрэг чиглэл бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Т.Жаргалсайхан

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Даваадорж

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Ганзориг

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ч.Багдал

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Баярсүх

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

С.Гантөмөр	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ю.Азамат	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
М.Ганзориг	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
П.Улаанхүү	-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч
Л.Батбаяр	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
М.Пүрэвхүү	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Г.Гончигсүрэн	-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Ц.Мягмарсүрэн	-Эрүүл мэндийн газрын дарга
Д.Даваасамбуу	-Статистикийн хэлтсийн дарга
Д.Батцэнгэл	-Мал эмнэлгийн газрын дарга
Т.Цэндхүү	-Барилгачдын холбооны тэргүүн
С.Батмөнх	-Хар-Ус нуур орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга
Э.Өлзийхүү	-Хүнсчдийн холбооны тэргүүн
Б.Ганзориг	-Ховд аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга
Д.Жүгдэрбарам	-Эдийн засагч
З.Бурмаа	-Ховд Их сургуулийн эрдэмтдийн төлөөлөл
П. Амарсанаа	-Аялал жуулчлалын холбооны дэд тэргүүн
Д.Ширэндэв	-Монгол Улсын Үйлчилгээний гавьяат ажилтан

Т.Цэндсүрэн

-Үр жимс хоршоо, Монгол Улсын
Гавьяат тариаланч

Д.Байгальмаа

-Дэлхийн байгаль хамгаалах сангийн
Ховд салбарын захирал

Нарийн бичгийн дарга: Б.Дариймаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-д тусгах санал боловсруулах ажлын удирдамжинд заагдсан ажлыг 05 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулж ажлын тайланг Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Т.Жаргалсайханд даалгасугай.

3.Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналыг удирдамжийн дагуу зохион байгуулж ажлын тайланг 04 дүгээр сарын 25-ны дотор аймгийн ажлын хэсэгт ирүүлэхийг бүх сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Хэлэлцүүлэг удирдамжийн дагуу зохион байгуулах зардлыг “Хариуцлагатай тунгалааг төр” хөтөлбөрөөс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг тур орлон гүйцэтгэгч /С.Гантэмөр/ нарт зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

